

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, ...болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд тус зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд 2-т “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.” гэж заасан.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа-ны зорилт 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд тус зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.1.3-т “Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.” гэж, 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.1-д “нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.1-д “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” 53 дугаар тогтоолын 2.1-д төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их

Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан зэрэг нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлснээс хойш тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, тэтгэврийн сангийн чадавхийг бэхжүүлэх, шимтгэл ногдуулах болон тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг тодорхойлох, тэтгэвэр тогтооход баримталсан цалин хөлсний дундаж хэмжээг тэтгэвэр авагчийн хүсэлтээр нэг удаа өөрчлөх боломжийг олгох, тэтгэвэр бодох жишиг цалинг тогтоох, үнэ ханшны өсөлт, амьжиргааны өртөгтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, эхчүүдийн хүүхдээ асрах чөлөөтэй байгаа хугацааны шимтгэл төлөх харилцааг зохицуулах зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2017-2018 онуудад нийгмийн даатгалын хууль эрх зүйн хүрээнд ажил олгогч болон даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2018 оноос үе шаттайгаар нэмэгдүүлж 19.0 хувьд хүргэх, өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх насыг 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 2037 онд эрэгтэй хүн, 2057 онд эмэгтэй хүний өндөр насны тэтгэвэрт гарах насыг тус тус 65 насанд хүргэх, хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар нэмэгдүүлж тооцохоор хуульчилсан. Мөн даатгуулагч өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2038 он хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлэх, малчны өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болзлыг 5 жилээр урагшлуулах, тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дараалсан хугацааг 7 жил болгон өөрчилж, дундаж цалингийн хэмжээг мөн хугацааны цалин хөлсний нийт дүнг 84 сард хувааж тооцох зэрэг зохицуулалтуудыг тус тус тусгасан¹.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг төрсөн оноос нь хамааруулан тогтоох, тэтгэврийн ердийн наснаас эрт тэтгэвэр тогтоолгох иргэдийн хувьд шимтгэл төлсөн байвал зохих хугацааг үе шаттайгаар өсгөх зэрэг тэтгэврийн параметрийн өөрчлөлтүүд хийж байгаа ч хүн амын насжилт, тэтгэвэр авагчдын тооны өсөлт нь тэтгэврийн даатгалын сангийн зардал, улсын төсвийн ачааллыг улам нэмэгдүүлж цаашид үүсэх асуудлуудыг нэг мөр шийдвэрлэж чадахгүйд хүрээд байна.

Дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засаг өөрчлөгдөж, 1990 оны дунд үеэс хүн ам насжиж, уламжлалт тэтгэврийн тогтолцооны засаглал, менежментийн сул талууд илэрч, тэтгэврийн зардал нэмэгдэн тэтгэврийн тогтолцоонд бэрхшээлтэй, тулгамдсан асуудлууд бий болсон. Олон улс орнууд насжилтаас хамааран үүсэх эрсдэлээс хамгаалах, ахмад настныг ядууралд өртөхөөс сэргийлэхийн тулд өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохирсон

¹ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульд нэмэлт оруулах, идйн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017 оны №13, 2017 оны № 16.

тэтгэврийн шинэчлэлийн бодлого, тэтгэврийн параметрийн өөрчлөлтүүдийг 20-25 жилийн өмнөөс авч эхэлсэн туршлага байна.

Европын орнуудаас Унгар, Польш, Латви, Эстони, Болгар, Литва, Словак, Румын зэрэг улсууд 1990-ээд оны сүүлч, 2000 оны эхээр уламжлалт хуваарилалтын зарчимд тулгуурласан тэтгэврийн тогтолцоог халж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлсэн. Түүнчлэн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Казахстан улс 1998 онд, ОХУ 2002 онд, Украин улс 2004 оноос, Киргиз улс 2010 оноос олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгох, эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах талаар дэвшүүлсэн зорилтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас 2020 онд 440.0 мянга гаруй тэтгэвэр авагчдад 2.2 их наяд төгрөг зарцуулна. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо нийт тэтгэвэр авагчдын 79 орчим хувь буюу 348.0 мянгад хүрсэн. Түүнчлэн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 байгаа бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсөж 2030 онд 7, цаашид 9 тэтгэвэр авагч болохоор байна.

Хүн амын дундаж наслалт 2019 онд 70.41² жил болж, 17 жилийн өмнөх дундаж наслалтын түвшинтэй харьцуулахад 6.9, 2009 оноос 2.45 жилээр тус тус өссөн бөгөөд эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.38 жил, эмэгтэйчүүдийнх 75.96 жил байна. 2019 онд 60-аас дээш насны хүн ам нийт хүн амын 7.0 хувь байгаа бол 2050 онд 28.6 хувь болж өсөхөөр байна.

Мөн 60 насандаа тэтгэвэрт гарснаас хойших эрэгтэйчүүдийн амьдрах хугацаа 2010 оны байдлаар 16 жил, 55 наснаас хойших эмэгтэйчүүдийн амьдрах хугацаа 22.1 жил байсан бол 2016 оны байдлаар эрэгтэйчүүдийнх 1.2 жилээр нэмэгдэж 17.1, эмэгтэйчүүдийнх 3.3 жилээр нэмэгдэж 25.4 жил³ болж өссөн байна. Энэ үзүүлэлт 2050 онд эрэгтэйчүүдийн хувьд 19.2 жил, эмэгтэйчүүдийн хувьд 27.1 жил болох судалгаа тооцоо гарч байгаа юм.

Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд 2010 онд 170.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бол энэ хэмжээ 2020 онд 2.3 дахин нэмэгдэж 399.4 тэрбум төгрөгт хүрсэн.

Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь 2019 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 1.8 хувь байгаа бол энэ

² www.1212.mn

³ Үндэсний статистикийн хороо, Хүн амын өсөлт, өөрчлөлт хандлага, 2017

үзүүлэлт 2030 онд 6.0 хувь, 2050 он гэхэд 11.0 хувь болж өсөх⁴ магадлал хэтийн тооцоо, судалгааны үр дүнгээс харагдаж байна. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 2030 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний 2.0 хувиас хэтрүүлэхгүй байхаар "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-д тусгасан бөгөөд уг зорилтыг хангахад тэтгэврийн параметрийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хийх зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн шимтгэл төлж ажилласан хугацаа, тэтгэвэр тогтоох насны талаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиас бусад салбарын хуульд тусгасан нь хууль хооронд зөрчил, хийдэл үүсгэж байна. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд Цэцийн гишүүнээр ажиллаж байсан иргэний өндөр насны тэтгэврийг цалингийн 60 хувиар бодох, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шүүгчээр 25 жил ажилласан, эсхүл 55 нас хүрсэн шүүгч, мөн Прокурорын тухай хуульд 50 насанд хүрсэн эмэгтэй, 55 насанд хүрсэн эрэгтэй, эсхүл нас харгалзахгүйгээр прокуророор 25 жил ажилласнаар тус тус өндөр насны тэтгэвэр тогтоолгож болохоор заасан нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай зөрчилдөж, хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Мөн одоо мөрдөж буй хуульд богино хугацааны буюу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох харилцааг даатгуулагчийн урт хугацааны тэтгэврийн харилцаатай нэгтгэн зохицуулсныг салгаж тусдаа хуулиар зохицуулах нь зүйтэй юм.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиар 1960 оноос хойш төрсөн иргэнд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулж байгааг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн зохицуулалттай нэгтгэн нэг хуулиар зохицуулах шаардлагатай байна. Түүнчлэн олон давхаргат тэтгэврийн тогтолцоог тодорхойлж, хуульд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хуулийн төслийг боловсруулахдаа тэтгэврийн даатгалын өнөөгийн тогтолцоонд Дэлхийн банк, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага болон гадаадын зөвлөхүүдийн хийсэн үнэлгээ, тайлан, санал, дүгнэлтийг харгалзан үзнэ.

Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны эрх зүйн хүрээг шинэчлэх бодит үндэслэл, хэрэгцээ, шаардлага байгаа нь тэтгэврийн сангийн өнөөгийн байдал, улсын төсвийн санхүүжилт, хүн ам зүйн ачаалал, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлын өөрчлөлт, олон улсын тэтгэврийн тогтолцооны чиг хандлага зэргээс тодорхой харагдаж байна.

Тэтгэврийн даатгалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох гол зорилго нь даатгуулагчид эрх тэгш, шударга, амьжиргаанд нь хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох, тэтгэврийн сангийн санхүүгийн тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэх, улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг бууруулах, даатгалд хамрагдах сонирхол, хөшүүргийг бий болгох, тэтгэврийн хэмжээг төлсөн шимтгэлтэй уялдуулах, тэтгэвэр тооцох аргачлалыг боловсронгуй болгох юм.

Иймд дээрх хууль зүйн үндэслэл болон нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон тэтгэмжийн талаарх харилцааг тусдаа хуулиар зохицуулах

⁴ Дэлхийн банк, "Тэтгэврийн шинэчлэлийн бодлогын хувилбарууд, 2017 он

практик шаардлагын дагуу тус хуулийн төслийн нэрийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль гэж өөрчлөн, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжтэй холбоотой харилцааг энэ хуулийн төслөөр зохицуулахгүй.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасныг үндэслэн хуулийн бүтэц уялдаа өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл нь тэтгэврийн даатгалд шимтгэл төлж даатгуулсан иргэнд олгох тэтгэврийн төрөл, тэтгэвэр авах эрх, тэтгэвэр тогтоох, өөрчлөх, олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл 7 бүлэгтэй бөгөөд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт, хуулийн зорилтыг тодорхойлж, хуулийн нэр томъёоны хүрээг өргөтгөж, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог тодорхойлж, тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн тэтгэврийн ердийн насанд хүрсэн даатгуулагчид суурь тэтгэвэр олгох, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл, тэтгэврийн төрлийг сонгох эрхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Гуравдугаар бүлэгт, өндөр насны тэтгэвэр авах эрх, өндөр насны тэтгэвэр бодох аргыг тодорхойлж, өндөр насны тэтгэврийг цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаар аргаар бодох, өндөр насны тэтгэвэр олгох хугацаа зэрэг зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, тэтгэврийн хэмжээ, олгох хугацаа, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн тогтоож, тэтгэврийг нөхөн олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

Тавдугаар бүлэгт, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх, тэтгэврийн хэмжээ, олгох хугацаа, нөхөн олгох, нэгтгэн тогтоох тухай зохицуулалтыг тусгана.

Зургадугаар бүлэгт, даатгуулагчийн тэтгэврийг тогтоох этгээдийг тодорхойлж, тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх, тэтгэвэр олгох, олголтыг түдгэлзүүлэх, зогсоох, сэргээх, тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох, тэтгэврээс суутгал хийх, тэтгэврийн хэмжээг индексжүүлэх, харилцааг зохицуулна.

Долдугаар бүлэг, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулахаар, мөн хуулийг

дагаж мөрдөх журмын зохицуулалт, хууль хүчин төгөлдөр болох харилцааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар бий болно. Үүнд:

- тэтгэврийн нэг давхаргат тогтолцооноос олон давхаргат тогтолцоонд шилжих эрх зүйн үндэс бүрдэнэ;

- тэтгэврийн насны өөрчлөлтийг даатгуулагчид эрсдэл багатайгаар хэрэгжүүлж, зохион байгуулах нөхцөл бүрдэнэ;

- даатгуулагчийн төлсөн шимтгэлтэй хамааралтай илүү шударга тэтгэвэр тооцох аргачлал нэвтрүүлнэ;

- даатгуулагчийн олон жил шимтгэл төлж ажиллахыг урамшуулж, тэтгэвэр тогтоолгох насанд хүрээд тэтгэврээ тогтоолгоогүй үргэлжлүүлэн ажилласан бол илүү ажилласан жил тутамд тэтгэвэр бодох хувийг нэмэгдүүлнэ;

- малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад тэтгэврийн даатгалын сангаас төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай, амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр авах бололцоогоор хангана;

- нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг хэрэглээний үнийн өөрчлөлт, цалин хөлсний өсөлтийг харгалзан жил бүр нэмэгдүүлж, тэтгэврийн худалдан авах чадварыг сайжруулах нөхцөл бүрдэнэ;

- тэтгэврийн даатгалын сангийн алдагдал болон улсын төсөвт учруулах ачааллыг урт хугацаанд зохистой байдлаар бууруулснаар ажил олгогч, даатгуулагчид үзүүлэх шимтгэлийн дарамтыг багасгана;

- тэтгэврийн даатгалын сан тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ;

- ирээдүйд бий болох хүн ам зүйн ачааллын өсөлт, насжилтыг угтаж тэтгэврийн тогтолцооны загварыг өөрчлөх замаар ахмад настанд тулгарах эрсдэлийг бууруулна;

- нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиас бусад хуульд заасан тэтгэвэр тогтоох нөхцөлийг энэ хуульд тусгаж, хууль хоорондын зөрчил арилж, уялдаа холбоо хангагдаж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах боломж бий болно.

4.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй.” гэж заасанд нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай, Монгол Улсын шүүхийн тухай, Прокурорын тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---